



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2. “Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000203

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2020 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн  
 130 дугаар тогтоолын хавсралт

"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦПАГАТАЙ КОМПАНИАС МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
 ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Тоёота лексус 570, 00-34 УНУ, JTJHY7AX5D4101269	Ш	1.00	198,000,000.00	198,000,000.00	-	6,000,000.00	4 жил
Нийт дүн				198,000,000.00	198,000,000.00	-	6,000,000.00	4 жил
				(нэг зуун ерэн найман сая)	(нэг зуун ерэн найман сая)		(зургаан сая)	